## БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

Огноо 2021-03-16

МХБ

Байгууллагын нэр

Зохион байгуулалтын нэгж,ажилтны нэр

| Бүртгэсэн | | Хаанаас | Баримт бичгийн | | |
|---|---|---|---|---|---|
| Сар, өдөр | Карт № | | Дугаар | Сар | Хуудасны тоо |
| 03/16 | 439 | МХБ Төлх ТУЗ | 03 | 3/09 | 3 |

Товч утга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Удирдлагын заалт @directors – шийдвэрлэх

MONGOLIAN STOCK EXCHANGE

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 2021 оны 03 сарын 09–ний хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК -ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 сарын 22-ны өдрийн 10 цагт Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газар II байр Д корпуст зохион байгуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
    a) Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт.
    b) Компанийн 2021 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.

3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 өдрийн дараа Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №2-р баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА М.БАТХУЯГ

Монголын Хөрөнгийн Биржийн УХА 0163 • ТУЗ •

1521010005

“МХБ” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн
..03.. дугаар Тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр: | “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК |
| Хаяг: | Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160, Монгол улс |
| Хурал хуралдах өдөр, цаг: | 2021 оны ... сарын ... |
| Хурал хуралдах газар /хаяг, байршил/: | Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газар II байр Д корпуст, Улаанбаатар хот |
| Хурлын төрөл: | Ээлжит |
| Хурал зарлагч: | Төлөөлөн удирдах зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: | ТУЗ-ийн 2021 оны 3 сарын 09-ний өдрийн Тогтоол № …. |
| Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/: | 1. Хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол.<br>2. Хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл. |
| Баримт бичгийн хуудасны тоо: | ......................... ширхэг |
| | .......................... хуудас |

........... оны ......... дүгээр сарын ........ –ны өдөр

"МХБ" ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн
03. дугаар Тогтоолын 2 дугаар хавсралт

КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. Компанийн санхүүгийн жилийн тайлан;
2. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
3. Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт;
4. Бизнесийн үйл ажиллагааны тайлан;
5. Хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчээс шаардсан бусад мэдээлэл.